

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/195/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭСАНТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага.....	18
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tiv@audit.gov.mn

2022.02.25 № 01/97
танай -ны № -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020333

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>113,594,203.67</u>	<u>80,697,589.39</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	113,594,203.67	80,697,589.39
351	Түүхий эд материал	93,360,250.17	60,980,435.89
35110	Тусгай зориулалттай материал	92,600,250.17	60,162,935.89
35130	Эм боох материал	760,000.00	817,500.00
354	Хангамжийн материал	20,233,953.50	19,717,153.50
35410	Бичиг хэргийн материал	9,200.00	00.00
35460	Хүнсний материал	532,800.00	25,200.00
35470	Бусад хангамжийн материал	19,691,953.50	19,691,953.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,003,715,445.08</u>	<u>3,058,971,291.67</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,003,715,445.08	3,058,971,291.67
392	Биет хөрөнгө	2,959,623,445.24	3,014,879,291.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,046,977,096.60	3,046,977,096.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	-157,851,940.20	-215,681,294.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	161,348,406.80	188,246,406.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-130,847,665.74	-101,646,259.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	94,289,567.36	118,724,464.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	-61,695,763.58	-30,224,234.60
39214	Бусад үндсэн хөрөнгө	456,860.00	456,860.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-42,180.00	-42,180.00
39217	Ном	6,989,064.00	8,068,433.00
393	Биет бус хөрөнгө	44,091,999.84	44,091,999.84
39301	Програм хангамж	1,370,000.00	1,370,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,356,000.16	-1,356,000.16
39303	Бусад биет бус хөрөнгө	44,078,000.00	44,078,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,117,309,648.75</u>	<u>3,139,668,881.06</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,117,309,648.75</u>	<u>3,139,668,881.06</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,117,309,648.75	3,139,668,881.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	544,201,863.95	544,201,863.95
51101	Өмч: - төрийн	544,201,863.95	544,201,863.95
512	Хуримтлагдсан үр дүн	1,904,961,358.80	1,928,414,605.12
51210	Өмнөх үеийн үр дүн	1,904,961,358.80	1,906,055,372.81
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	22,359,232.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	668,146,426.00	667,052,411.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,117,309,648.75</u>	<u>3,139,668,881.06</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,684,005,571.91	1,746,084,192.58	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,645,171,171.91	1,390,899,756.58	
120	Нийтлэг татварын бус орлого	13,480,071.91	134,598,056.58	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,480,071.91	134,598,056.58	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,480,071.91	134,598,056.58	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,631,691,100.00	1,256,301,700.00	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,339,659,800.00	1,256,301,700.00	
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	292,031,300.00		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	38,834,400.00	355,184,436.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,834,400.00	43,521,236.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,834,400.00	43,521,236.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	311,663,200.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	311,663,200.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,742,555,838.82	1,723,724,960.27	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,742,555,838.82	1,723,724,960.27	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,590,515,099.60	1,641,163,909.85	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,040,553,568.02	1,006,438,405.58	
210101	Үндсэн цалин	667,786,084.51	674,647,592.29	
210102	Нэмэгдэл	289,119,458.51	230,608,618.85	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,212,239.00	34,136,144.51	
210104	Урамшуулал	61,435,786.00	67,046,049.93	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,161,851.76	135,866,912.13	
210201	Тэтгэврийн даатгал	95,581,499.95	95,614,105.20	
210202	Тэтгэмжийн даатгал	6,910,333.05	10,063,753.78	
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,419,302.01	8,050,602.99	
210204	Ажилгүйдлийн даатгал	538,983.24	2,011,053.73	
210205	Эрүүл мэндийн даатгал	19,711,733.51	20,127,396.43	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	287,847,920.00	306,314,311.00	
210301	Гэрэл, цахилгаан	6,644,420.00	5,642,911.00	
210302	Түлш, халаалт	279,478,500.00	298,121,400.00	
210303	Цэвэр, бохир ус	1,725,000.00	2,550,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	6,473,093.00	5,285,616.00	
210401	Бичиг хэрэг	776,600.00	1,137,540.00	
210402	Тээвэр, шатахуун	1,299,193.00	886,876.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	716,700.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	253,000.00	300,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,344,300.00	2,244,500.00	
2105	Нормативт зардал	38,160,300.00	47,485,670.00	

Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,296,000.00	638,000.00
210502	Хоол, хүнс	34,366,100.00	43,931,570.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,498,200.00	2,916,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,068,400.00	999,600.00
210604	Урсгал засвар	1,068,400.00	999,600.00
2107	Томилолт, зочны зардал	300,000.00	446,000.00
210702	Дотоод албан томилолт	300,000.00	446,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,941,400.00	43,406,884.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,941,400.00	43,406,884.87
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,008,566.82	94,920,510.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	126,000.00	1,199,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,327,078.00	3,724,414.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	82,555,488.82	89,996,496.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	152,040,739.22	82,561,050.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,454,300.00	77,902,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,914,900.00	41,068,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,576,000.00	15,680,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,258,400.00	19,406,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,705,000.00	1,747,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,586,439.22	3,597,961.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,586,439.22	3,597,961.42
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,060,289.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,060,289.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(58,550,266.91)</u>	<u>22,359,232.31</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(58,550,266.91)</u>	<u>22,359,232.31</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	544,201,863.95	668,146,426.00	1,963,511,625.71	3,175,859,915.66
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	544,201,863.95	668,146,426.00	1,963,511,625.71	3,175,859,915.66
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн			(58,550,266.91)	(58,550,266.91)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	544,201,863.95	668,146,426.00	1,904,961,358.80	3,117,309,648.75
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	544,201,863.95	668,146,426.00	1,904,961,358.80	3,117,309,648.75
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	544,201,863.95	668,146,426.00	1,904,961,358.80	3,117,309,648.75
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			22,359,232.31	22,359,232.31
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	544,201,863.95	668,146,426.00	1,927,320,591.11	3,139,668,881.06

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,670,525,500.00</u>	<u>1,611,486,136.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,631,691,100.00	1,256,301,700.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,631,691,100.00	1,256,301,700.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,339,659,800.00	1,256,301,700.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	292,031,300.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	38,834,400.00	355,184,436.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,834,400.00	43,521,236.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,834,400.00	43,521,236.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	311,663,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	311,663,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,668,552,350.00</u>	<u>1,597,180,767.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,668,552,350.00	1,597,180,767.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,516,511,610.78	1,514,661,716.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,040,553,568.02	1,006,438,405.58
210101	Үндсэн цалин	667,786,084.51	674,647,592.29
210102	Нэмэгдэл	289,119,458.51	230,608,618.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,212,239.00	34,136,144.51
210104	Урамшуулал	61,435,786.00	67,046,049.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,161,851.76	135,866,912.13
210201	Тэтгэврийн даатгал	95,581,499.95	95,614,105.20
210202	Тэтгэмжийн даатгал	6,910,333.05	10,063,753.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,419,302.01	8,050,602.99
210204	Ажилгүйдлийн даатгал	538,983.24	2,011,053.73
210205	Эрүүл мэндийн даатгал	19,711,733.51	20,127,396.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	287,847,920.00	306,303,311.00
210301	Гэрэл, цахилгаан	6,644,420.00	5,642,911.00
210302	Түлш, халаалт	279,478,500.00	298,110,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,725,000.00	2,550,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,712,300.00	4,370,740.00
210401	Бичиг хэрэг	728,800.00	1,131,240.00
210402	Тээвэр, шатахуун	724,000.00	750,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	716,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	320,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,139,500.00	1,472,800.00
2105	Нормативт зардал	37,648,300.00	48,522,770.00

Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	363,000.00	599,000.00
210502	Хоол, хүнс	34,526,300.00	43,423,970.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,759,000.00	4,499,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	999,600.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	999,600.00
2107	Томилолт, зочны зардал	300,000.00	446,000.00
210702	Дотоод албан томилолт	300,000.00	446,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,969,400.00	4,999,987.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,969,400.00	4,999,987.87
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,318,271.00	6,713,990.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	251,000.00	1,699,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,067,271.00	5,014,390.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	152,040,739.22	82,519,050.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,454,300.00	77,860,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,914,900.00	41,068,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,576,000.00	15,680,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,258,400.00	19,406,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,705,000.00	1,705,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,586,439.22	3,597,961.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,586,439.22	3,597,961.42
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,060,289.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,060,289.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,973,150.00	14,305,369.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,973,150.00	14,305,369.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,973,150.00	14,305,369.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,973,150.00	14,305,369.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,973,150.00	14,305,369.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,973,150.00)	(14,305,369.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,567,964,900.0	1,563,306,785.6	4,658,114.4	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,567,964,900.0	1,563,306,785.6	4,658,114.4	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,523,728,800.0	1,520,533,285.6	3,195,514.4	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,006,473,500.0	1,006,438,405.6	35,094.4	100.0
210101	Үндсэн цалин	661,423,000.0	674,647,592.3	(13,224,592.3)	102.0
210102	Нэмэгдэл	245,927,500.0	230,608,618.9	15,318,881.2	93.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,076,000.0	34,136,144.5	(2,060,144.5)	106.4
210104	Урамшуулал	67,047,000.0	67,046,049.9	950.1	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,873,800.0	135,866,912.1	6,887.9	100.0
210201	Тэтгэврийн даатгал	95,615,100.0	95,614,105.2	994.8	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	10,064,800.0	10,063,753.8	1,046.2	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,051,700.0	8,050,603.0	1,097.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,012,900.0	2,011,053.7	1,846.3	99.9
210205	Эрүүл мэндийн даатгал	20,129,300.0	20,127,396.4	1,903.6	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	307,363,200.0	306,303,311.0	1,059,889.0	99.7
210301	Гэрэл, цахилгаан	6,252,800.0	5,642,911.0	609,889.0	90.2
210302	Түлш, халаалт	298,110,400.0	298,110,400.0	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.0	2,550,000.0	450,000.0	85.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5,985,000.0	5,942,309.0	42,691.0	99.3
210401	Бичиг хэрэг	700,000.0	697,440.0	2,560.0	99.6
210402	Тээвэр, шатахуун	750,000.0	750,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	750,000.0	716,700.0	33,300.0	95.6
210404	Ном, хэвлэл	485,000.0	479,369.0	5,631.0	98.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.0	300,000.0	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.0	2,998,800.0	1,200.0	100.0
2105	Нормативт зардал	50,567,300.0	48,522,770.0	2,044,530.0	96.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	600,100.0	599,000.0	1,100.0	99.8
210502	Хоол, хүнс	45,467,200.0	43,423,970.0	2,043,230.0	95.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,500,000.0	4,499,800.0	200.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,300,000.0	4,299,600.0	400.0	100.0
210604	Урсгал засвар	4,300,000.0	4,299,600.0	400.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	446,000.0	446,000.0	-	100.0
210702	Дотоод албан томилолт	446,000.0	446,000.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,000,000.0	4,999,987.9	12.1	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн	5,000,000.0	4,999,987.9	12.1	100.0

Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж				
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,720,000.0	7,713,990.0	6,010.0	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,700,000.0	1,699,600.0	400.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,020,000.0	6,014,390.0	5,610.0	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,236,100.0	42,773,500.0	1,462,600.0	96.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,236,100.0	42,773,500.0	1,462,600.0	96.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,531,100.0	41,068,500.0	1,462,600.0	96.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,705,000.0	1,705,000.0	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,567,964,900.0	1,567,964,900.0	-	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,256,301,700.0	1,256,301,700.0	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,256,301,700.0	1,256,301,700.0	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	311,663,200.0	311,663,200.0	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	311,663,200.0	311,663,200.0	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	80.0	80.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	4.0	4.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	35.0	35.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	41.0	41.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/төгрөгөөр/	
			Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	38,834,400.00	38,834,400.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,834,400.00	38,834,400.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,834,400.00	38,834,400.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,834,400.00	38,834,400.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,576,000.00	11,576,000.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,258,400.00	27,258,400.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	38,834,400.00	38,834,400.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,834,400.00	38,834,400.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,834,400.00	38,834,400.00	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дах Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургууль нь сургуулийн аюулгүй, сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлж, сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хүүхэд бүрийн хүмүүжил, хөгжил, төлөвшил, сурлагын чанарт ахиц гаргахыг зорилгоо болгон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн Захирлын 2018 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн А/23 дугаар тушаалаар томилогдсон дотоод хяналтын баг нь 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө 16 чиглэлээр гарган баталгаажуулж, дотоод хяналтыг гүйцэтгэн, ажлын тайланг улирал бүр гарган ажилласан байна.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө, Төв аймгийн Засаг дарга бөгөөд дотоод аудитын хорооны даргын баталсан удирдамжийн дагуу 2019, 2020 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 1,567,964.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 23,519.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 17,639.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 1,567,964.9 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 38,834.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 1,614,943.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 81,618.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 62,554.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,079.4 мянган төгрөгийн ном, нийт 145,252.3 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 14,305.4 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 38,106.9 мянган төгрөгийн, дахин үнэлгээний нэмэгдэл 92,840.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 3,651.1 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 98,335.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 134,883.1 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дангүй байна. Бараа материал 80,697.6 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 3,058,971.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага	-	-	-
Урьдчилгаа			-
Бараа материал	113,594.20	80,697.59	(32,896.61)
Үндсэн хөрөнгө	3,003,715.44	3,058,971.29	55,255.85
Нийт хөрөнгө	3,117,309.64	3,139,668.88	22,359.24
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,117,309.64	3,139,668.88	22,359.24
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,117,309.64	3,139,668.88	22,359.24

Бараа материалын дансны үлдэгдэл 80,697.6 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 32,896.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,058,971.3 мянган төгрөг болж 55,255.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого нэмэгдсэнээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,139,668.9 мянган төгрөг болж 22,359.2 мянган төгрөгөөр өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 1,567,964.9 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 1,523,728.8 мянган төгрөг, татаас ба урсгал шилжүүлгийн зардалд 44,236.1 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,523,728.8 мянган төгрөгийн урсгал зардал, 44,236.1 мянган төгрөгийн татаас ба урсгал шилжүүлгийн зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 1,567,964.9 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 1,563,306.8 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 4,658.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,563,306.8 мянган төгрөг буюу 99.7 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 38,834.4 мянган төгрөг төвлөрч, урсгалд зардалд 38,834.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 81,618.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 62,554.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,079.4 мянган төгрөгийн ном, нийт 145,252.3 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 14,305.4 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 38,106.9 мянган төгрөгийн, дахин үнэлгээний нэмэгдэл 92,840.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 3,651.1 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 98,335.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 134,883.1 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна.

3.8 Аудитын гол асуудал

Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 1,503.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, цалингаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш 2 удаагийн нийт 43,270.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс 145 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроож, цалингаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш 2 удаагийн 43,270.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 8,970.6 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гараагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 51,561.8 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 6,478.1 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 310.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 44,773.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 6,478.1 мянган төгрөгийн 2 алдааг залруулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг шалгахад 32 нэр төрлийн 56,110.7 мянган төгрөгийн хөрөнгийн 3,283.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулаагүй, элэгдлийн зардлыг дутуу тооцоолон тайлагнасан нь: УСНББОУС 17-той нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Өмнөх оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үлдэгдлийг тайлант оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлтэй тулган шалгахад санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын зүйлийн дүн 3,194.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 310.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд үр дүнгийн урамшуулалт цалин олгохдоо байгууллагын удирдлагын тушаалаар баталсан хувь хэмжээг нэмэгдүүлэн 3 албан хаагчид 310.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин илүү олгосон нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон урамшуулалт цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 1,503.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвий тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал, ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

2. *Шилэн данстай холбоотой асуудал*

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 145 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

3. *Шилэн данстай холбоотой асуудал*

3.1. Илрүүлэлт:

Цалингаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш 2 удаагийн нийт 43,270.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургууль	6	51,561.8	2	6,478.1	1	310.1	-	-	3	44,773.6

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn